



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь Гурвансайхан орон сууцны корпораци ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ӨМА-2026/056/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.Umnugovi@audit.mn](mailto:www.Umnugovi@audit.mn)

Өмнөговь аймаг

2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn  
Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn  
Ахлах аудитор: Г.Шижирболд  
Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn  
Аудитор: Ө.Болортуяа  
Утас: 70533552 Цахим хаяг: Bolortuyau@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	6
5.1 Төлбөрийн акт .....	6
5.2 Албан шаардлага .....	6
5.3 Зөвлөмж .....	6
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	7

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.16 № 308

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

"ӨМНӨГОВЬ ГУРВАНСАЙХАН ОРОН  
СУУЦНЫ КОРПОРАЦИ" ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Ж.ЭРДЭНЭБОЛД ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 -д заасны дагуу Өмнөговь Гурвансайхан орон сууцны корпораци ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбоход дэмжлэг үзүүлэх тухай журмын дагуу 605,176.9 мянган төгрөгөөр 127 өрхийг цэвэр усны шугамд, 61 өрхийг бохир усны шугамд холбох ажлыг зохион байгуулсан байна.

#### Аудитын гол асуудал

Тайлант онд 8,569,590.6 мянган төгрөгийн 59 айлын 2644.76 м2 байрыг бүртгэлд тусгаж, 74 иргэнтэй түрээсийн гэрээ байгуулсан байна.

#### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгагдсан асуудал нь хамаарахгүй болно.

4626750457  
F:\2 Бичиг хэрэг\2026он\СТА-н дүгнэлт\Төсөл.Досх



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,143,825,737.61	3,078,160,284.50
2	Дансны авлага	6,050,000.00	6,050,000.00
3	НДШ-ын авлага	625,832.18	625,832.18
4	ХХОАТ-ын авлага	0.00	7,883,841.83
5	Бусад авлага	26,582,501.37	22,852,501.37
6	Бараа материал	16,841,950.00	15,759,050.00
7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,700,000.00	16,340,000.00
8	Бусад эргэлтийн хөрөнгө	124,016,825.00	164,016,825.00
9	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,323,642,846.16	3,311,688,334.88
10	Үндсэн хөрөнгө барилга	34,642,008,382.32	42,492,694,843.31
11	Биет бус хөрөнгө	1,320,000.00	990,000.00
12	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	34,643,328,382.32	42,493,684,843.31
13	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>36,966,971,228.48</b>	<b>45,805,373,178.19</b>
14	Цалингийн өглөг	0.00	22,099.00
15	Татварын өр	29,244,269.24	33,584,350.79
16	Хөрөнгө бэлтгэхтэй холбоотой тооцоо	124,016,825.00	164,016,825.00
17	Урьдчилж орсон орлого	849,127,915.12	1,234,114,623.11
18	Бусад богино хугацаат өр төлбөр	388,698,925.79	483,991,364.79
19	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,391,087,935.15	1,915,729,262.69
20	Хойшлогдсон татварын өр	34,528,814,148.06	42,374,169,275.49
21	Урт хугацаат өр төлбөрийн дүн	34,528,814,148.06	42,374,169,275.49
22	Өр төлбөрийн нийт дүн	35,919,902,083.21	44,289,898,538.18
23	Өмч: а) төрийн	8,000.00	8,000.00
24	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	1,047,061,145.27	1,515,466,640.01
25	Эздийн өмчийн дүн	1,047,069,145.27	1,515,466,640.01
26	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>36,966,971,228.48</b>	<b>45,805,373,178.19</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого ( цэвэр )	1,312,001,799.00	1,373,246,541.54
2	Борлуулалтын өртөг	1,171,557,648.69	1,338,494,020.53
3	Нийт ашиг	140,444,150.31	34,752,521.01
4	Түрээсийн орлого	0.00	768,069,595.54

**Өмнөговь Гурвансайхан орон сууцны корпораци ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

5	Хүүний орлого	109,040,847.22	152,376,619.93
6	Эрхийн шимтгэлийн орлого	910,780.00	0.00
7	ХТӨр дансны ХЭХЗОрлого	537,954,901.00	724,235,454.53
8	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	7,674,600.00
9	Ерөнхий ба удирдлагын зардал	249,288,094.46	383,239,445.76
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	539,062,584.07	520,450,549.71
11	Орлогын татварын зардал	53,906,258.41	52,045,054.97
12	Татвар дараах ашиг (алдагдал)	485,156,325.66	468,405,494.74
13	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	485,156,325.66	468,405,494.74

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Мөнгөн орлогын дүн (+)	1,583,466,008.82	2,017,024,743.75
2	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	755,903,411.60	1,254,822,156.82
3	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
4	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,888,335.00	-
5	Татаас, санхүүжилтийн орлого /ЦБУсны хөнгөлөлт/	711,136,155.00	605,176,946.00
6	Бусад мөнгөн орлого /Хүүгийн орлого болон бусад/	109,040,847.22	152,376,619.93
7	Мөнгөн зарлагын дүн (-)	1,033,061,729.83	1,086,490,196.86
8	Ажиллагчдад төлсөн	132,358,141.00	234,378,090.00
9	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	39,517,850.00	64,426,366.05
10	Бараа материалын худалдан авахад төлсөн	31,675,633.66	36,229,445.27
11	Түлш шатахуун	-	292,200.00
12	Татварын байгууллагад төлсөн	37,887,676.17	79,638,838.25
13	Бусад мөнгөн зарлага	59,159,829.00	19,505,073.00
14	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,309,456,624.35	934,334,546.89
15	Мөнгөн зарлагын дүн ( - )	-	16,034,000.00
16	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
17	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
18	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,309,456,624.35	934,334,546.89
19	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	834,369,113.26	2,143,825,737.61
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,143,825,737.61	3,078,160,284.50

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31 - ний үлдэгдэл	8,000.00	-	-	1,047,061,145.27	1,047,061,145.27
2	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	-	-	468,405,494.74	468,405,494.74
3	2025 оны 12- р сарын 31- ний үлдэгдэл	8,000.00	-	-	1,515,466,640.01	1,515,466,640.01

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 2,652,918.3 мянган төгрөгийн 5 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн. Үүнд:

*Залруулсан алдаа:*

- Ерөнхий журналаас орлогын тайлангийн борлуулсан бүтээгдэхүүний өртөгтэй тулган баталгаажуулахад 39,761.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Тайлант онд 2,602,573.1 мянган төгрөгийн хөрөнгийг дутуу тайлагнасан;
- Ерөнхий ба удирдлагын зардлын бүртгэлийн дэлгэрэнгүйг тулган баталгаажуулахад ББӨ-г тусгах 9,081.6 мянган төгрөгийн зардал бүртгэсэн;
- Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 18 дугаар тогтоолоор 1,502.0 мянган төгрөгийн 2 ширхэг хөрөнгийг актлах шийдвэр гарсан боловч тайлант онд акталж, данс бүртгэлээс хасаагүй,
- Жилийн эцсийн санхүүгийн тайлантай хамт тайлангийн тодруулга бэлтгэж ирүүлээгүй байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 7,496.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 9,612.7 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага их тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй байна.

### 5.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагааг түүвэрлэн шалгахад бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөнөөр нээлттэй сонгон шалгаруулаагүй, худалдан авах ажиллагааг олон нийтэд мэдээлэлгүйгээр 7,496.0 мянган төгрөгийн хөрөнгийг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 35 дугаар зүйлийн 35.2-д "Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ", Төрийн хэмнэлтийн туай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллах.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ерөнхий журналаас орлогын тайлангийн борлуулсан бүтээгдэхүүний өртөгтэй тулган баталгаажуулахад 39,761.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	39,761.5			1	39,761.5	1	39,761.5				
Тайлант онд 2,602,573.1 мянган төгрөгийн хөрөнгийг дутуу тайлагнасан	1	2,602,573.1	1	2,602,573.1			1	2,602,573.1				
Ерөнхий ба удирдлагын зардлын бүртгэлийн дэлгэрэнгүйг тулган баталгаажуулахад ББӨ-т тусгах 9,081.6 мянган төгрөгийн зардал бүртгэсэн	1	9,081.6			1	9,081.6	1	9,081.6				
Тайлант онд 1,502.0 мянган төгрөгийн 2 ширхэг хөрөнгийг актлах шийдвэр гарсан боловч тайлант онд акталж, данс бүртгэлээс хасаагүй	1	1,502.0	1	1,502.0			1	1,502.0				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>2,652,918.2</b>	<b>2</b>	<b>2,604,075.1</b>	<b>2</b>	<b>48,843.1</b>	<b>5</b>	<b>2,652,918.2</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Өмнөговь Гурвансайхан орон сууцны корпораци ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын тайлан

1	Худалдан авах ажиллагааг түүвэрлэн шалгахад бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөнөөр нээлттэй сонгон шалгаруулаагүй, худалдан авах ажиллагааг олон нийтэд мэдээлэлгүйгээр 7,496,000 төгрөгийн хөрөнгийг шууд гэрээ байгуулан худалдан авсан байна	1	7,496.0			1	7,496.0						
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>7,496.0</b>			<b>1</b>	<b>7,496.0</b>						

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Хариуцлага тооцох албан шаардлага		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансны мэдээллийн системд 180 мэдээлэл байршуулхаас 10 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	1	0					1	0
<b>Дүн</b>									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
1									
<b>Дүн</b>									
<b>Нийт дүн</b>								-	